

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 04 ДҮГЭЭР САРЫН
1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ**

2018.04.05

	Хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэ вэл зохих асуудал	Бусад асуудал
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ажилтнуудын гамшгаас хамгаалах зарлан мэдээллийн дохиогоор бүх албан хаагчдийг бүрэн оролцуулан ажиллаа.		
2	Улаанбаатар хотод “Уул уурхайн байгаль орчныг хамгаалал, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын тооллого” сэдэвт семинарт газрын дарга болон холбогдох мэргэжилтэнг удирдах ажилтны зөвлөгөөнд газрын дарга оролцлоо.		
3	Алтай сумын 1-р багийн Цалгар зуслангийн "Доод Ёлтын хавцал" гэдэг газарт нутагшин хаваржиж байгаа аргаль хонь угалзад тус сумын Байгаль хамгаалагч нар хяналт тавьж мониторингийн ажиглалтын судалгаа хийллээ.		
4	Улаанбаатар хотод 19 дэх жилдээ зохион байгуулагдсан "ITM-2018" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Манай аймгаас 32 аялал жуулчлалын компани, зочид буудал, гар урлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаний төлөөлөл хамрагдаж байгаа бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга А.Гылымхан оролцлоо. Тус аялал жуулчлалын үзэсгэлэн нь оролцогчдын тоо, цар хүрээний хувьд Монгол улсын хэмжээнд зохион байгуулагддаг хамгийн том үзэсгэлэн төдийгүй, нийслэл хот, 21 аймаг орон нутгийн төлөөлөл бүрэн хамрагдаж шинэ бүтээн байгуулалт, үйлчилгээгээ сурталчлан танилцуулахаас гадна аялал жуулчлалын бизнес эрхлэгчид бүтээгдэхүүнээ борлуулах, түншлэлийн гэрээ хэлэлцээр хийх, гадаад, дотоодын судлаачдын төрөлжсөн хэлэлцүүлэг, семинарт оролцох боломжийг бий болгодог давуу талтай юм. Оролцож байгаа төлөөлөлүүдэд үзэсгэнгийн дараа 2 өдөр стандарт үйлчилгээ, хамтын ажиллагаа, бодлого төлөвлөлтийг сайруулах, аймагт ирэх жуулчдын тоог нэмүүлэх ажлын хүрээнд Монголын Аялал Жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн дэмжлэгтэйгээр дүгнэлт хийх хэлэлцүүлэг, 5 одтой зочид буудал, Чингэсийн Хүрээ АЖЦ, Хустайн нурууны УТХГ-уудад туршлага соллох ажилд тус тус оролцов.		

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

